

АЖЛЫН ДААЛГАВАР

ТӨСЛИЙН ХААЛТЫН ТАЙЛАН БЭЛТГЭХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨХ

Дэлхийн банкны зээлийн дугаар: LN 9082-MN; CR 6594-MN; CR 6833-MN

Төслийн нэр: Монгол Улсад КОВИД-19 халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл (нийт төсөв 77.6 сая ам.доллар, төсөл 2020 оны 4-р сарын 24-нд эхэлсэн бөгөөд 2024 оны 9-р сарын 30-нд дуусна)

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Эрүүл мэндийн яамны хэрэгжүүлж буй “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн хүрээнд уг төслийн Засгийн газрын хаалтын тайланг бэлтгэх гэрээг санхүүжүүлнэ.

Энэхүү зөвлөх үйлчилгээний орон тоотой холбоотой ажлын даалгавар, шалгуур үзүүлэлт болон бусад мэдээллийг доор дэлгэрэнгүй дурдсан болно.

1. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хяналт шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-ний зөвлөх нь хяналт-шинжилгээ, үнэлгээ, эрүүл мэндийн бодлого, төрийн бодлого, эдийн засаг болон бусад холбогдох мэргэжлийн аль нэг чиглэлээр их дээд сургууль төгссөн, олон улсын санхүүгийн байгууллага эсвэл Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, НҮБ зэрэг олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжсэн төсөлд ХШҮ-ний чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан байна. Мөн зөвлөх нь хамгийн багадаа 2 (хоёр) Төслийн хаалтын тайлан эсвэл Хэрэгжилтийн тайланг ганцаарчлан бэлтгэн гүйцэтгэсэн эсвэл гүйцэтгэлийн багийн гишүүнээр ажиллаж байсан туршлагатай байх шаардлагатай бөгөөд тухайн тайлангуудын аль нэг нь 15 сая ам.доллароос багагүй төсөвтэй төслийн тайлан байх ёстой. ХШҮ-ний зөвлөх нь англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байна. Мөн тоон болон чанарын мэдээлэл цуглуулах, судалгаа хийх, үнэлэн дүгнэх чадвартай байна.

2. ХУГАЦАА

Зөвлөх үйлчилгээний гэрээг 2024 оны 5-р сараас 2024 оны 9-р сар хүртэлх хугацаанд байгуулахаар төлөвлөж байна.

3. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ, АЖЛЫН ДААЛГАВАР

Зөвлөх нь Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН), Эрүүл мэндийн яам (ЭМЯ), Сангийн яам, Дэлхийн банк болон бусад холбогдох талуудтай хамтран төслийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, “Монгол Улсад КОВИД-19 халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн хаалтын тайланг хийж гүйцэтгэнэ.

Тодруулбал дараах ажлыг хийж гүйцэтгэнэ:

(i) Төслийн Санхүүжилтийн хэлэлцээр, Төсөл хэрэгжүүлэх заавар, санамж бичиг, төслийн улирал, жилийн үйл ажиллагааны тайлангууд, ТХН болон бусад зөвлөхүүдийн тайлан, Төслийн удирдах хорооны тогтоолууд, Төслийн аудитын тайлангууд болон төслийн бусад бүхий л баримт бичигтэй танилцан, мэдээлэл цуглуулна.

(ii) Зөвлөх нь Засгийн газрын хаалтын тайланг Монгол, Англи хэл дээр хийж гүйцэтгэх, Дэлхийн банкны хэрэгжилтийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэхэд хувь нэмэр оруулахтай холбогдуулан төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх өгөгдөл, баримт мэдээллийг нэгтгэн цуглуулах арга хэрэгслийг боловсруулна.

(iii) Монгол Улсын Засгийн газрын холбогдох хууль тогтоомж, тэр дундаа Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-д нийцүүлэн Эрүүл мэндийн яамыг төлөөлөн Төслийн Засгийн газрын хаалтын тайланг бэлтгэн боловсруулна. Ингэхдээ тайланд дараах зүйлсийг тусгасан байна.

- (1) Төслийн танилцуулга, мэдээлэл
- (2) Төслийн хүрээнд гүйцэтгэсэн үндсэн үйл ажиллагаа
- (3) Төслийн төсөв зарцуулалт, зардал
- (4) Төслийн хуваарь
- (5) Хэрэгжилтийн зохион байгуулалт
- (6) Зөвлөх, Гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчийн гүйцэтгэл
- (7) Зээлдэгч, хэрэгжүүлэгч байгууллагын гүйцэтгэл
- (8) Дэлхийн банкны гүйцэтгэл
- (9) Төслийн зорилтын хэрэгжилтийн үнэлгээ (үр дүн, үзүүлэлт, тогтвортой байдал, төслийн үр дүн, Монгол Улсын Засгийн газрын хөгжлийн бодлогын нийцэл)
- (10) Төслийн хэрэгжилт ба үр дүнд нөлөөлсөн голлох хүчин зүйлсэд хийсэн дүн шинжилгээ (хэрэгжүүлэх болон бэлтгэх явцад гарсан гол хүчин зүйлс)
- (11) Төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлын үнэлгээ
- (12) Төслийн хүрээнд гарсан ололт амжилт
- (13) Засгийн газар, ЭМЯ, Дэлхийн банкинд өгөх зөвлөмж
ТАЙЛБАР: Энэхүү жагсаалтыг урьдчилсан байдлаар гаргасан бөгөөд жагсаалтад нэмэлт өөрчлөлт орох боломжтой.

(iv) ЭМЯ болон Дэлхийн банкны хүсэлтээр төслийн тухайлсан үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

АЖЛЫН ДААЛГАВРЫН ХҮСНЭГТ:

Утга	Даалгаврын нэр	Дуусгах хугацаа
Монгол Улсад КОВИД-19 халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл		
Даалгавар 1	Баримт, мэдээллийг нэгтгэн цуглуулах арга хэрэгслийг боловсруулах	2024 оны 6-р сарын 20
Даалгавар 2	Хаалтын тайлангийн төслийг бэлтгэн батлуулах	2024 оны 7-р сарын 30
Даалгавар 3	Хаалтын тайланг эцэслэн, бэлэн болгох	2024 оны 8-р сарын 30

4. ЗАХИАЛАГЧИЙН ОРОЛЦОО БОЛОН ХАМТРАГЧ ТАЛУУД

- (a) Захиалагчаас Зөвлөхөд үзүүлэх үйлчилгээ, оффис талбай, бусад хангамж: ТХН-ийн оффис талбайд ширээ, сандал, оффис принтер, хувилагч төхөөрөмж, интернэт холболт
- (b) Захиалагчаас зөвлөхөд томилох мэргэжлийн болон туслах ажилтан: Байхгүй
- (c) Захиалагчаас Зөвлөхөд тайлан бэлтгэхтэй холбоотой хангах баримт бичиг: Засгийн газраас хангаж болох бүх өгөгдөл мэдээлэл.